

БАТЛАВ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ТӨСЛИЙН УДИРДАГЧ
П.ДАВХАРБАЯР

2019 оны 10... сарын 01... өдөр

Д.ЛУВСАНШАРАВЫН НЭРЭМЖИТ ХҮҮХДИЙН НАЙРАЛ
ДУУНЫ ШИЛДЭГ ХАМТЛАГ ШАЛГАРУУЛАХ ХХV УДААГИЙН
УРАЛДААНТ НААДМЫН УДИРДАМЖ

2019 оны 09 дүгээр сарын 27-ний өдөр

Улаанбаатар хот

Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд бүрийн авъяасыг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болон зохиогддог Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг” шалгаруулах 27 дахь удаагийн уралдаант наадмыг Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойд зориулан дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулж байна.

Зохион байгуулалт:

Бүртгэл: 10 дугаар сарын 04-ний өдрийн 17.00 цаг хүртэл дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс 502 тоотод явагдана. Сургуулиуд бүртгүүлэхээр ирэхдээ мэдүүлгээ авчирна. /Жич: Мэдүүлгийг хөгжмийн багш нар заасан хугацаанд өөрийн биеэр авчирарх ба нэр, холбоо барих утасны дугаараа тэмдэглэнэ/

Дүүргийн шалгаруулалтыг 10 дугаар сарын 09-ний өдөр 10 цагт Монголын хүүхдийн ордны урлаг зааланд зохион байгуулна. Дүүргийн шалгаруулалтанд нутаг дэвсгэрийн бүх сургуулиуд оролцох ба 3 хамтлагийг шалгаруулж, 2 дугаар шатны шалгаруулалтанд оролцуулна.

2 дугаар шатанд шалгарсан хамтлагууд мэдүүлгээ дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэст 10 дугаар сарын 13-ны өдрийн 17.00 цагаас өмнө ирүүлнэ.

2 дугаар шатны шалгаруулалт 10-р сарын 16-ны өдөр Монголын хүүхдийн ордонд болно.

2 дугаар шатанд амжилттай оролцсон найрал дууны хамтлагуудын нэгдсэн тоглолт нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 380 жилийн ойд зориулан 2019 оны 10 дугаар сарын 28-нд Соёлын төв өргөөнд болно.

Уралдаанд тавигдах шаардлага:

Уралдаант наадамд хамтлаг тус бүр нийт 3 бүтээлээр оролцоно. Үүнд:

а/ Заавал дуулах бүтээл

б/ Акапелла буюу хөгжимгүй найрал дуу

в/ Чөлөөт уран сэтгэмж бүхий найрал дуу /шоу хэлбэрийн/

Уралдаанд оролцогчдыг дараах үндсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

1. Найрал дууны дуугаралт /хөг, үг хэллэг, хүчдэл, нийлэмж/
2. Хөгжмийн мэдрэмж утга санааг илэрхийлэх чадвар

3. Удирдаач багшийн ур чадвар
4. Бэлтгэл зохион байгуулалт /Тайзны соёл, хувцаслалт, хүүхдийн тоо 60-100 байх/ зэрэг шалгуургаар дүгнэж дараах байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

Уралдааныг мэргэжлийн эрдэмтэн багш нар, уран бүтээлчид дүгнэнэ.

Уралдааны шагнал, урамшуулал:

Тэргүүн байр	1	Өргөмжлөл	Мөнгөн шагнал
Дэд байр	1	Өргөмжлөл	Мөнгөн шагнал
Гуравдугаар байр	1	Өргөмжлөл	Мөнгөн шагнал
Тусгай байр	1	Өргөмжлөл	Мөнгөн шагнал
Шилдэг удирдаач багш-1		Өргөмжлөл	Мөнгөн шагнал

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

Харилцах утас : 70070128, 99810977 – Золзаяа
Мэйл хаяг: sbd_zolzaya85@yahoo.com